

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31	
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК						
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	АЧАА ТЭЭВЭРЛЭГЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ						
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал						
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр			Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай			2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input type="checkbox"/> Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй						
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог			Нэр			
		Балсан			Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.								
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх							
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл								
9	Даатгалын зүйл	Даатгуулагчийн гэрээнд заасан тээврийн хэрэгслээр ачаа тээшийг тээвэрлэх явцдаа тээвэрлэлтийн үйл ажиллагааны тээвэрлэж буй ачаанд учруулсан хохиролд хүлээх хариуцлага						
	Даатгалын үндсэн эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Ачаа тээш тээвэрлэн замын хөдөлгөөнд оролцох үед тээврийн хэрэгслийн техникийн гэнэтийн эвдрэл, гэмтлээс үүдэн тээвэрлэж буй ачаа бараанд учрах эрсдэл; - Тээвэрлэгч жолоочийн буруутай үйлдлээс зам тээврийн осол гарч ачаа тээшинд учрах хохирол; - Ачаа тээшийг тээвэрлэлтэнд бэлдэж байх үед гэнэтийн осол аваараас үүдэн тээвэрлэх гэж буй ачаа тээшинд учрах хохирол; - Галын; - Байгалийн; - Ажил мэргэжлийн алдааны; - Тээвэрлэлтийн үеийн /ахуйн/; 						
	Даатгалын нэмэлт эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Зам тээврийн хөдөлгөөний үеийн; - Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдлийн; 						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	1,0%-3,5%						

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

1. Даатгагч Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 8.5 дугаар зүйлд заасан үндэслэл үүссэн болон энэхүү даатгалын онцлогоос хамаарч дараах тохиолдлуудад аливаа үүрэг хариуцлага хүлээхгүй бөгөөд нөхөн төлбөр төлөхөөс татгалзана.
 - 1.1 Ажил үүргээ гүйцэтгэж явсан ажилтан, албан хаагчдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол;
 - 1.2 Даатгуулагчийн өөрийн тээврийн хэрэгсэл болон бусдын жолоодож явсан тээврийн хэрэгсэл, түүний тээж явсан ачаанд учруулсан хохирол;
2. Ердийн элэгдэл, бараа материалын хэвийн хорогдол, ууршилт зэрэг тухайн эд хөрөнгө бараа материалын шинж чанараас шалтгаалан гарсан хохирол;
3. Гэрээнд заасан тээврийн нөхцөл, тээвэрлэлтийн маршрут гэх мэт гол өөрчлөлтүүдийг цаг тухайд нь даатгагчид мэдэгдээгүй бол; Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд энэ заалт хамаарахгүй ба даатгуулагч энэ тухайгаа нотлох үүрэгтэй.
4. Ашиглалтын хугацаа хэтэрсэн техник тоног, төхөөрөмжөөр тээвэрлэлт хийсэн, ажиллах даац, ачаалал хэтрүүлсэн, тээврийн хэрэгсэлд техникийн шаардлага хангаагүй засвар үйлчилгээ хийсний үр дагавраас үүссэн хохирол;
5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журам зааврыг ноцтойгоор зөрчснөөс үүдэн гарсан хохирол;
6. Тухайн нарийн мэргэжлийн ажлыг хийх эрхгүй этгээд буюу мэргэжлийн үнэмлэхгүй ажилтны үйл ажиллагаанаас үүдсэн хохирол;
7. Ослын талаар даатгагчид хүндэтгэх шалтгаангүйгээр 72 цагийн дотор мэдэгдээгүй, ослын талаар холбогдох мэргэжлийн байгууллагын акт дүгнэлт гаргуулаагүй, ослын талаар дүгнэлт хийх боломжгүй болсон бол;
8. Хууль зөрчсөн үйл ажиллагаанаас үүдсэн хохирол түүний үр дагавар;
9. Хадгалалтын горим, хугацаа, үйлдвэрлэлийн гэмтэл гологдол зэргээс үүссэн хохирол;
10. Замд саатсан шалтгааны улмаас үүссэн санхүүгийн алдагдал болон бүх хэлбэрийн алданги, хүү, торгууль;
11. Ачаа тээшний шинж чанараас хамааран гарах эрдлүүд. Өөрөөр хэлбэл тээвэрлэлтийн нөхцөл шаардах ачаа тээшийг журмын дагуу тээвэрлээгүй бол,
12. Сав баглаа боодол, бэхэлгээ нь стандарт бус, шаардлага хангаагүй байдлаас үүдэн гарсан хохирол,
13. Бүтээгдэхүүний шошго, сав баглаа боодолд учирсан хохирол;
14. Гэрээгээр тусгайлан тохирч даатгуулагүй бол хулгай, түүний үр дагавар;
15. Даатгалын тохиолдол мөн эсэх нь нотлогдоогүй буюу нотлогдох боломжгүй болсон;
16. Дайн, зэвсэгт бослого, үймээн самуун, террорист үйл ажиллагаа, Ажил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, бослого, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр зэргийн улмаас үүссэн нөхцөл байдал, улс төрийн тэмцэлд оролцсоноос үүссэн;
17. Байлдааны зэвсэг хэрэглэх, цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт бодис буюу туяаны хордлого;
18. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл.